

Сэлэнгэ аймгийн Ерөө сумын нутгаас шинээр илрүүлсэн Сяньбигийн үеийн дурсгалт газрын мэдээ

Төмөр-Очирын Идэрхангай, Лхагвасүрэнгийн Хүслэн,
Амарбатын Гүнчинсүрэн

Монгол улсын нутаг дэвсгэрт өнөөг хүртэл олон угсаатан, ард түмэн амьдарч өөрсдийн түүхийг гэрчлэх олон арван археологийн дурсгалуудыг үлдээсэн байдаг билээ. Гэвч тэдгээрээс зарим үеийн түүхэнд холбогдох дурсгалыг маш бага судалсан байдгийн нэг нь Сяньбигийн үеийн дурсгал юм. Саяхныг хүртэл энэ үеийн түүхэнд холбогдох археологийн дурсгалууд олдохгүй байсан бол 2014 оноос манай судлаачид Сэлэнгэ, Дархан-Уул, Орхон аймгийн нутаг буюу Сэлэнгэ, Орхон голын сав газраас тэдэнтэй холбоотой дурсгалуудыг илрүүлэн олж, сяньбичүүд тухайн бүс нутагт аж төрөн оршин тогтнож байсан нь илэрхий болж байна. Бид энэ удаад уг бүс нутгаас шинээр илрүүлэн олсон Сяньбигийн үеийн оршуулгын дурсгалын талаар мэдээлж байна. Энэхүү дурсгалт газрыг анх 2025 оны 1-р сард агаарын зургийн хайгуулын явцад олж илрүүлсэн бөгөөд 2025 оны 4-р сарын сүүлээр тухайн газар дээр нь очиж бүртгэл судалгааны ажлыг хийж гүйцэтгэв (Идэрхангай нар, 2025).

Дурсгалт газар нь Сэлэнгэ аймгийн Ерөө сумын төвөөс хойд зүгт 15 км орчим зайд, сумын нутгийн хойд хэсгээр байрлах Хангайн нуруунаас урагш нуруулдсан хоёр талаараа өргөн ам бүхий Дөмбөн хэмээх уулын хойд үзүүрээр Баруун Шинстэйн амнаас Зүүн Шинстэйн ам руу давах шороон замын хойд талд, хойноос урагш нуруулдсан хамрын орой хэсгийн тэгш дэвсгэ дээр гүн жалгын хоёр талаар байрлана. Энд гадна талаараа усан татаал шуудуу бүхий нийт 32 бунхант булш байгаагаас жалгын урд талд 8, хойд талд 24 байх ажээ. Бунхант булшнууд гадаад зохион байгуулалтын хувьд 2 ялгаатай байх ба дан шороон овгор бүхий булш 10, гадна талаараа чулуун дараастай шороон овгор булш 22 байна. Том хэмжээтэй бунхант булшнуудын гадна талаар усан татаал шуудуу мэдэгдэж байсан бол жижиг хэмжээний дурсгалуудад сайн мэдэгдэхгүй байв. Мөн зарим дурсгалыг тонож хөндсөн бололтой шороон овгорын төв хэсэгт том хэмжээний хонхор илт мэдэгдэнэ. Дан шороон овоолготой булшнууд жалгын хойд талд буюу дурсгалт газрынхаа баруун хойд талаар байрласан бөгөөд хамгийн том хэмжээтэй булш 10 x 10 м, өндөр нь 1,5 м бол бусад дурсгалын хувьд дундаж хэмжээ

нь 7 x 7 м байна. Харин шороон овгорын гадна талаар чулуун дараас үйлдсэн бунхант булшнуудын хувьд хамгийн том дурсгал нь энэ газрын зүүн захад байрлах ба усан татаал шуудуу нь 12 x 13 м, бунхант булшны дараас 10 x 9 м хэмжээтэй, 1,8 м өндөртэй байгаа бол бунхант булшнуудын дундаж хэмжээ нь 6 x 6 м ажээ.

Монгол нутаг дахь Сяньбигийн үеийн дурсгалын судалгаа бусад үеийн дурсгалтай харьцуулахад харьцангуй хожуу эхэлсэн байдаг. Судлаачид энэ үед холбогдох булш оршуулгын дурсгалуудыг 2010 онд Өмнөговь аймгийн Ханбогд сумын Булан тойром (Амартүвшин, Батзориг 2015), 2015-2016 онд Баян-Өлгий аймгийн Ногооннуур сумын Бургастын гол (Төрбат нар 2016: 114-119), 2017-2018 онд Баян-Өлгий аймгийн Цэнгэл сумын Шивээт хайрхан (Батболд нар 2018: 123-128) зэрэг газруудад малтан судалж байсан бол сяньбичүүдтэй шууд холбоотой байж болох язгууртны оршуулгын дурсгалыг Ц.Одбаатар нарын судлаачид 2014 оноос Орхон аймгийн Жаргалант сумын Айрагийн гозгор (Одбаатар нар 2024) хэмээх газраас олж илрүүлэн малтан судлаад байгаа юм. Булан тойром, Бургастын гол, Шивээт хайрхан зэрэг дурсгалт газрууд нь Сяньбигийн цаг үед хамаарах жирийн иргэдийн дурсгалууд байсан бол Айрагийн гозгор нь Сяньбичүүдийн ихэс дээдэс, язгууртнуудад холбогдох боломжтой дурсгалт газар байснаараа онцлог юм. Манай судалгааны баг 2018 оноос эхлэн Сэлэнгэ аймгийн нутаг, тэр дундаа Орхон голын сав дагуух Хүннүгийн үеийн оршуулгын дурсгалт газруудын бүртгэл судалгааны ажлыг явуулж эхэлсэн бөгөөд тус судалгааны ажлын явцад Хүннүгийн үеийн булшнаас гадна өөр цаг үед холбогдох шинэ төрлийн дурсгалуудыг илрүүлсний дотор сяньбичүүдтэй хамаатай хэд хэдэн оршуулгын дурсгалт газрыг 2018-2022 онуудад шинээр нээж бүртгэн баримтжуулсан болно. Бидний бүртгэл судалгааны ажлын явцад Дархан-Уул аймгийн Хонгор сумын Гавилуй уул, Сэлэнгэ аймгийн Баруунбүрэн сумын Хонгор Овоо, Орхонтуул сумын Агьтийн өвөр, Ерөө сумын Карников (Идэрхангай нар 2022: 137), Ерөө сумын Салхит уул (Идэрхангай нар 2024а: 27), Орхон сумын Улаан чулуут уул (Идэрхангай нар 2024б) хэмээх газруудад шороон болон чулуун овгор дараас

бүхий Сяньбигийн үед холбогдох 6 дурсгалт газрыг илрүүлээд байна. Мөн 2024 онд ШУА-ийн судлаачид “Монголын Эзэнт гүрний археологи” төслийн хүрээнд Сэлэнгэ, Дархан-Уул аймгийн зарим сумдын нутгийг хамарсан хайгуул судалгааны ажлын хүрээнд Сэлэнгэ аймгийн Ерөө сумын Хөх чулуут (Эрэгзэн нар 2024: 231) хэмээх газраас Сяньбигийн үеийн 14 бунхант булш бүхий оршуулгын дурсгалт газрыг шинээр илрүүлжээ. Ингэснээр одоогийн байдлаар манай улсын нутаг дэвсгэр дээрээс Орхон аймгийн Жаргалант сумын Айрагийн гозгор, Сэлэнгэ аймгийн Орхон сумын Улаан чулуут уул, Орхонтуул сумын Агьтийн өвөр, Баруунбүрэн сумын Хонгор овоо, Ерөө сумын Карников, Салхит уул, Хөх чулуут, Дархан-Уул аймгийн Хонгор сумын Гавилуй уул гэсэн 8 дурсгалт газар илэрч мэдэгдээд байгаа бөгөөд эдгээр нь бүгд Монгол орны хойд бүс нутаг буюу Орхон голын сав газраас илэрсэн бөгөөд шинээр бүртгэсэн Баруун Шинстэйн дурсгалт газар мөн л тухайн бүс нутагт илрэн олдсон нь сяньбичүүдийн уугуул нутаг Орхон, Сэлэнгэ мөрний сав газар байсныг, тэд энэ бүс нутагт төвлөрөн төрийн үйл хэргийг гүйцэтгэж байсныг харуулж буй түүхэн баталгаа юм.

Баруун Шинстэйн дурсгалт газарт буй дурсгалууд шороон овгор байгууламжтай, түүний гадуур усан татаал шуудуутай гэсэн нийтлэг зохион байгуулалттай бол шороон овгор нь дан шороон болон чулуун дараастай гэсэн хоёр төрөлтэй бөгөөд 10 булшийг дан шороогоор, 22 булшийг шороон овгорын гадна талаас нэмэлтээр чулуун дараас үйлдэн хучиж байгуулсан ба энд 32 бунхант булш байгаа нь харьцангуй том дурсгалт газар болохыг харуулж байна. Дээрх 9 дурсгалт газарт буй булшнуудыг хооронд нь харьцуулж үзвэл Баруун Шинстэй, Салхит уул, Хөх чулуутаас бусад дурсгалт газруудад жирийн иргэдийн цагирган дарааст булш болон Хүннүгийн язгууртны булшнууд хамт байдгаараа онцлог бол энэ 3 дурсгалт газар зөвхөн сяньбичүүдтэй холбоотой бунхант булшнууд байгаа явдал юм.

Баруун Шинстэйн дурсгалт газар нь Сэлэнгэ аймгийн Ерөө сумын нутгаас олдож буй дөрөв дэх оршуулгын газар бөгөөд Сяньбигийн оршуулгын дурсгалын томоохон төвлөрөл энэ бүс нутагт байсныг давхар баталж байна. Бид энэхүү дурсгалт газарт нарийвчилсан судалгаа хийх, цаашлаад дурсгалт газрын түүхэн үнэ цэн, ач холбогдлыг тодорхойлох үүднээс археологийн системтэй малтлага судалгааны ажлыг явуулахаар төлөвлөж байна.

Ном зүй

Амартүвшин, Ч., Батзориг, О. (2015). Булан тойромын булш. *Studia Archaeologica*, Том. XXXV, Fasc.24. УБ.

Батболд, Н., Батсүх, Д., Баярхүү, Н., Өмирбек, Б., Жон Сон Муг. (2018). Монгол-Солонгосын хамтарсан “Соёлын өвийг судалж хамгаалах” төслийн 2018 оны судалгааны үр дүн. *Монголын археологи-2018*. УБ.

Идэрхангай, Т., Хүслэн, Л., Гүнчинсүрэн, Л. (2025). Хөвсгөл, Сэлэнгэ аймгуудын зарим бүс нутагт явуулсан археологийн хайгуул судалгааны ажлын тайлан. МУИС-ийн Нүүдэлчдийн Археологийн хүрээлэнгийн ГБСХ. УБ.

Идэрхангай, Т., Цэнд, Д., Амгаланбат, Б. (2022). Хүннү, Сяньби гүрний улс төрийн төв ба хүн амын төвлөрөл (Сэлэнгэ, Архангай, Булган аймгуудын нутагт 2018-2020 онд явуулсан Хүннү булшны бүртгэл судалгааны үр дүнгээс). *Journal of Archaeology, History and Culture*. Journal of the School of Ulaanbaatar, NUM. Vol. 18 (17). УБ.

Идэрхангай, Т., Цэнд, Д., Эрдэнэпүрэв, П., Батчимэг, Б., Хүслэн, Л., Намсрайжамц, А., Баянсан, Б., Уянга, Х., Энхзул, Ж., Батхишиг, М., Мөнхжин, М. (2024а). Монгол орны нутаг дахь Сяньбигийн үеийн дурсгалын судалгаа ба Дархан-Уул аймгийн Хонгор сумын Гавилуй уулын дурсгалт газрын малтлага судалгааны 2021-2023 оны үр дүнгээс. “Дарханы түүх, соёл: эрт, эдүгээ” эрдэм шинжилгээний хурлын эмхэтгэл. УБ.

Идэрхангай, Т., Эрдэнэпүрэв, П., Батчимэг, Б., Хүслэн, Л., Намсрайжамц, А., Энхзул, Ж., Баянсан, Б., Мөнхжин, М. (2024б). Сэлэнгэ аймгийн Орхон сумын нутаг Улаан чулуут уулын дурсгалт газарт явуулсан археологийн малтлага судалгааны ажлын 2024 оны тайлан. МУИС-ийн Нүүдэлчдийн Археологийн хүрээлэнгийн ГБСХ. УБ.

Одбаатар, Ц., Даваацэрэн, Б., Нямбат, М., Бүрэнтөгс, Г., Энхболд, С., Эгиймаа, Ц. (2024). Айрагийн гозгорт явуулсан археологийн судалгаа. 2014-2017 оны судалгааны ажлын тайлан. УБ.

Төрбат, Ц., Баярхүү, Н., Лепец, С., Бернанд, В., Заззо, А. (2016). “Монгол Алтайн түрүү түүхэн ба түүхэн үеийн оршин суугчдын цогц судалгаа” төслийн 2016 оны хээрийн шинжилгээний товч үр дүн. *Монголын археологи-2016*. УБ.


Эрэгзэн, Г., Батболд, Н., Содномжамц, Д., Түвшинжаргал, Т. (2024). “Монголын Эзэнт гүрний археологи” төслийн хүрээнд 2024 онд Сэлэнгэ, Дархан-Уул аймгийн зарим сумдын нутагт хийсэн хайгуул судалгааны үр дүн. *Монголын Археологи-2024*. УБ.

Received: May 13, 2025; Revised: May 30, 2025;
Accepted: June 5, 2025





Зураг 1. Баруун Шинстэйн дурсгалт газар хойд талаас



Зураг 2. Баруун Шинстэйн дурсгалт газрын агаарын зураг



Зураг 3. Баруун Шинэстэйнн шороон дараастай бунхант були



Зураг 4. Баруун Шинэстэйн чулуун дараастай бунхант були